



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/93

Шивээговь сум

Сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/134 дугаар захирамжаар батлагдсан “Сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.1.3, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103-н жилийн ой, Шивээговь сум үүсгэн байгуулагдсаны 35 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн Мэдээллийн технологийн багш Баянмөнхийн Мөнхсоёл, Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Ганхуягийн Бум-Аюуш, Сумын Аварга адуучин Батсайханы Батмөнх, Ахмад настан Удвалын Тогоо нарыг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2.Шагналд зарцуулагдах 120,000 (нэг зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа), нярав (Б.Баярцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА